

Шашны Тусгай Хичээл болон Ёс Зүйн Тусгай Хичээлд Оролцох Тухай Бичиг

Шинэ Өмнөд Уэльс буюу NSW мужийн улсын боловсролын тогтолцоо нь сурагчдад шашин, ёс суртахуун болон ёс зүйн боловсролын хичээлд эцэг, эх/асран хамгаалагчийн сонголтын дагуу хамрагдах боломж олгодоггоороо онцлог юм.

Та доорх холбоос дээр дарж сургуулийн цахим хуудаснаас эцэг, эх/асран хамгаалагчид сонголт хийхэд нь туслах мэдээлэлтэй танилцана уу.

Сургуулийн цахим хуудас руу орох холбоос

Эцэг, эх/асран хамгаалагчид хүссэн үедээ бичгээр мэдэгдэл ирүүлж, өөрсдийн сонголтыг өөрчлөх боломжтой. Хэрэв эцэг, эх/асран хамгаалагч сонголтоо өөрчлөх хүсэлт гаргаагүй бол сурагчид өмнөх жилийнхээ сонголтоор үргэлжлүүлэн суралцана.

Хэрэв таны сонгосон Шашны Тусгай Хичээл (Special Religious Education (SRE)) эсвэл Ёс Зүйн Тусгай Хичээлийн сонголтууд (Special Education in Ethics (SEE)) сургуулийн хөтөлбөрт байхгүй бол албан ёсны, зөвшөөрөл бүхий боловсролын байгууллагатай холбоо барина уу. Эдгээр хичээлүүдэд сурагчид хамрагдахгүй тохиолдолд, үүний оронд багш нарын хараа хяналтан доор, сурагчдад хэрэгтэй бусад хөтөлбөрийг хэрэгжүүлэх болно.

Шашны Тусгай Хичээл болон Ёс Зүйн Тусгай Хичээлийн дэлгэрэнгүй мэдээлэл болон зөвшөөрөл бүхий боловсролын байгууллагын жагсаалтыг харахыг хүсвэл дараах холбоосоор орно уу: [Шашин болон ёс зүйн боловсрол](#)

Сургуулийн нэр

Дээрх нэр дурдсан сургуулиудаас дараах сонголтуудыг хийх боломжтой. Хэрэв таны хүүхэд Шашны Тусгай Хичээл болох SRE -д хамрагдахыг хүсвэл нэг сонголтыг хийн, тухайн нүдэнд тэмдэглэгээ тавина уу.

SRE Сонголтууд (SRE Options)

- | | |
|-----------|-------|
| Сонголт 1 | _____ |
| Сонголт 2 | _____ |
| Сонголт 3 | _____ |
| Сонголт 4 | _____ |
| Сонголт 5 | _____ |
| Сонголт 6 | _____ |
| Сонголт 7 | _____ |

ЭСВЭЛ

Хэрэв та хүүхдээ Шашны Тусгай Хичээл болох SRE-д хамрагдуулахыг хүсэхгүй байвал энэ нүдэнд тэмдэглэгээ хийнэ үү. (Student will not participate in SRE)

Доорх мэдээллийг Англи хэлээр бөглөж, гарын үсэг зурж сургуулийн захиргаанд буцаан өгнө үү.

Сурагчийн нэр	_____	Хэддүгээр анги болох	_____
	Student name		Year
Эцэг эх/асран хамгаалагчийн гарын үсэг	_____	Огноо	_____
	Signature of parent/carer		Date

Утсан орчуулгын үйлчилгээ

Хэрвээ танд дэлгэрэнгүй мэдээлэл болон орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн хэл дээрх орчуулагч авах хүсэлтэй байгаагаа хэлнэ үү. Операторт залгах дугаараа хэлснээр тухайн шугамд таны яриаг орчуулах орчуулагчийг холбох болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.

Та Шашны Тусгай Хичээл эсвэл Ёс Зүйн Тусгай Хичээлийг сонгохыг зөвшөөрснөөр энэхүү хичээлийг заах албан ёсны боловсролын байгууллагад таны хүүхдийн нэрийг өгөхийг зөвшөөрч байгаа гэсэн үг юм. Боловсролын Яам нь 1998 оны Хувийн нууц болон Хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн (NSW) 26-р зүйлд заасны дагуу таны зөвшөөрлийг авах шаардлагатай. Ингэснээр таны хүүхдийн мэдээллийг бусдад өгөхийг хориглосон уг хуулийн 19-р зүйлийг дагаж мөрдөх шаардлагаас Боловсролын Яам чөлөөлөгдөх юм.